



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/194/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayaq@audit.gov.mn</p> <p>Аудитор Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

дэлг. од. 16 № 1304/15
тантай _____ -ны № _____ -г

ХИЛИЙН ЦЭРГИЙН 0277 ДУГААР
АНГИЙН ЗАХИРАГЧ Б.УЛАМЖАРГАЛ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022914

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мян.төг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,219,116.2	1,376,192.9
33	АВЛАГА	0.0	2,125.6
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	1,500.0
335	Бусад авлага	0.0	625.6
3351	Байгууллагаас авах авлага	0.0	625.6
34	УРЬДЧИЛГАА	1,665.6	1,516.4
34600	Урьдчилж гарсан зардал	1,665.6	1,516.4
35	БАРАА МАТЕРИАЛ	1,217,450.6	1,372,550.9
351	Түүхий эд материал	18,324.4	25,777.4
35110	Тусгай зориулалттай материал	3,270.0	4,251.0
35130	Эм боох материал	15,054.4	21,526.5
35300	Бэлэн бүтээгдэхүүн	246,713.0	292,671.2
354	Хангамжийн материал	432,938.9	503,166.8
35410	Бичиг хэргийн материал	2,805.8	5,895.5
35420	Аж ахуйн материал	73,371.9	100,020.5
35430	Сэлбэг хэрэгсэл	28,889.6	36,860.0
35440	Түлш, шатах тослох материал	42,034.6	58,010.4
35450	Барилгын засварын материал	6,708.6	4,570.7
35460	Хүнсний материал	152,585.1	171,323.7
35470	Бусад хангамжийн материал	126,543.4	126,486.1
35500	Биологийн хөрөнгө	15,429.3	16,366.4
35600	Мал амьтад	504,045.0	534,569.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,322,545.2	4,010,934.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,322,545.2	4,010,934.3
392	Биет хөрөнгө	1,580,494.1	1,270,632.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	663,834.6	663,834.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	-99,012.8	-148,519.2
39203	Авто-тээврийн хэрэгсэл	898,037.2	898,037.2
39204	Хуримтлагдсан элэгдэл	-321,671.3	-520,697.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	294,604.4	378,712.6
39206	Хуримтлагдсан элэгдэл	-90,370.4	-172,809.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,428.2	88,428.2
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,672.6	-51,599.0
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	241,481.8	243,482.8
39212	Хуримтлагдсан элэгдэл	-61,862.4	-108,702.2
39214	Бусад үндсэн хөрөнгө	930.0	930.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-232.5	-465.0

393	Биет бус хөрөнгө	2,742,051.1	2,740,301.5
39301	Програм хангамж	9,634.4	9,722.4
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,597.3	-8,435.0
39303	Бусад биет бус хөрөнгө	2,739,014.0	2,739,014.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,541,661.4	5,387,127.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	34,785.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	34,785.3
413	Өглөг	0.0	34,785.3
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	34,785.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,541,661.4	5,352,341.9
51	Засгийн газрын хувь оролцоо	5,541,661.4	5,352,341.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,450,681.7	4,450,681.7
51101	Өмч: - төрийн	4,450,681.7	4,450,681.7
512	Хуримтлагдсан үр дүн	263,590.7	74,271.1
51210	Өмнөх үеийн үр дүн	263,590.7	263,590.7
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	-189,319.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	827,389.0	827,389.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,541,661.4	5,387,127.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,329,529.4	4,964,764.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,193,145.9	543,029.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,193,145.9	543,029.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	595,318.9	156,638.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,984.8	97,427.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	582,334.1	59,211.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,136,383.5	4,421,735.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,116,488.3	4,405,051.3
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,116,488.3	4,405,051.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,895.2	16,684.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,545.2	1,058.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,350.0	15,625.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,866,729.5	5,154,084.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,864,179.5	5,154,084.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,272,693.9	4,309,213.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,613,544.4	2,680,168.6
210101	Үндсэн цалин	2,522,393.2	1,523,646.6
210102	Нэмэгдэл	91,151.2	1,122,522.0

Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	0.0	34,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,522.6	176,762.6
210201	Тэтгэврийн даатгал	114,432.2	107,936.2
210202	Тэтгэмжийн даатгал	27,283.6	8,235.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,854.2	4,764.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,213.5	1,181.8
210205	Эрүүл мэндийн даатгал	52,739.1	54,644.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,292.9	97,430.5
210301	Гэрэл, цахилгаан	30,650.0	24,165.1
210302	Түлш, халаалт	41,642.9	73,265.4
2104	Хангамж, бараа материалын зардал	253,422.8	227,500.0
210401	Бичиг хэрэг	7,468.4	4,741.8
210402	Тээвэр, шатахуун	201,360.6	167,824.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,248.0	2,811.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,880.0	35,351.9
210408	Бараа материал акталсны зардал	16,465.8	16,770.6
2105	Нормативт зардал	681,138.2	638,300.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,710.7	19,083.0
210502	Хоол, хүнс	442,252.9	399,947.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	228,174.6	219,270.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,400.6	61,247.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	4,890.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	2,500.0
210604	Урсгал засвар	39,400.6	53,857.1
2107	Томилолт, зочны зардал	2,000.0	2,154.0
210702	Дотоод албан томилолт	2,000.0	2,154.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,731.4	27,768.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,722.3	20,255.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	940.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,996.7	6,347.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,236.2	0.0
210807	Газрын төлбөр	2,836.2	1,166.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	390,641.0	397,881.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,046.1	0.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	357,595.0	397,881.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	591,485.7	844,870.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,447.2	10,390.8
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,447.2	10,390.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	575,038.5	828,867.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	46,100.0	40,320.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	112,560.0	115,500.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	182,706.2	308,358.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	232,872.3	355,989.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800.0	8,700.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	5,612.5

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	5,612.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,550.0	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	2,550.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	462,799.8	-189,319.6
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.0	0.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	462,799.8	-189,319.6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мян.төг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,450,681.72	516,497.20	-55,327.48	4,911,851.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	109.74	109.74
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,450,681.72	516,497.20	-55,217.74	4,911,961.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-237,962.75	-237,962.75
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,450,681.72	827,389.01	263,590.70	5,541,661.42
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,450,681.72	827,389.01	263,590.70	5,541,661.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,450,681.72	827,389.01	263,590.70	5,541,661.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-189,319.56	-189,319.56
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,450,681.72	827,389.01	74,271.14	5,352,341.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,170,433.51	4,455,065.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,050.00	33,330.52
120	Нийтлэг татварын бус орлого	34,050.00	33,330.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,050.00	33,330.52
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,050.00	33,330.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,136,383.51	4,421,735.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,116,488.27	4,405,051.30
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,116,488.27	4,405,051.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,895.24	16,684.16
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,545.24	1,058.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,350.00	15,625.56
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,165,483.51	4,451,865.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,165,483.51	4,451,865.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,573,997.85	3,606,995.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,625,138.94	2,680,330.32
210101	Үндсэн цалин	1,570,533.18	1,523,808.32
210102	Нэмэгдэл	882,816.60	1,122,522.00
210104	Урамшуулал	39,400.00	34,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	132,389.17	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,062.68	177,226.47
210201	Тэтгэврийн даатгал	192,908.08	123,691.88
210202	Тэтгэмжийн даатгал	8,154.60	9,873.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	3,270.26
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,733.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	38,657.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,353.60	75,960.00
210301	Гэрэл, цахилгаан	30,650.00	22,278.83
210302	Түлш, халаалт	52,703.60	53,681.17
2104	Хангамж, бараа материалын зардал	224,109.73	216,923.26
210401	Бичиг хэрэг	2,900.00	5,595.36
210402	Тээвэр, шатахуун	194,815.13	167,744.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000.00	2,811.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,394.60	40,772.10
2105	Нормативт зардал	360,258.91	362,720.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,876.00	13,610.00
210502	Хоол, хүнс	341,382.91	339,110.07
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000.00	10,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,177.00	64,061.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,235.00	6,501.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,699.00	2,500.00

Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	38,243.00	55,060.50
2107	Томилолт, зочны зардал	2,000.00	2,154.00
210702	Дотоод албан томилолт	2,000.00	2,154.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,396.98	27,619.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,722.30	20,255.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	940.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,662.30	6,198.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,236.20	0.00
210807	Газрын төлбөр	2,836.18	1,166.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	591,485.66	844,870.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,447.20	10,390.80
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,447.20	10,390.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	575,038.46	828,867.35
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	46,100.00	40,320.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	112,560.00	115,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	182,706.16	308,358.03
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	232,872.30	355,989.32
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800.00	8,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	5,612.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5,612.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,950.00	3,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,950.00	3,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,950.00	3,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,950.00	3,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,950.00	3,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,950.00	-3,200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ мян.төг /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,437,051.30	4,432,769.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,437,051.30	4,432,769.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,597,793.15	3,593,511.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,680,330.32	2,680,330.32
210101	Үндсэн цалин	1,525,644.90	1,523,808.32
210102	Нэмэгдэл	1,120,685.42	1,122,522.00
210104	Урамшуулал	34,000.00	34,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,508.47	177,226.47
210201	Тэтгэврийн даатгал	115,702.00	123,691.88
210202	Тэтгэмжийн даатгал	11,860.20	9,873.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,935.50	3,270.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,209.50	1,733.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,801.27	38,657.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,960.00	75,960.00
210301	Гэрэл, цахилгаан	30,300.00	22,278.83
210302	Түлш, халаалт	45,660.00	53,681.17
2104	Хангамж, бараа материалын зардал	200,239.10	200,239.10
210401	Бичиг хэрэг	5,467.00	5,595.36
210402	Тээвэр, шатахуун	151,060.00	151,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,940.00	2,811.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,772.10	40,772.10
2105	Нормативт зардал	362,720.07	362,720.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,610.00	13,610.00
210502	Хоол, хүнс	339,110.07	339,110.07
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000.00	10,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,261.50	67,261.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,701.00	9,701.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500.00	2,500.00
210604	Урсгал засвар	55,060.50	55,060.50
2107	Томилолт, зочны зардал	2,154.00	2,154.00
210702	Дотоод албан томилолт	2,154.00	2,154.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,619.70	27,619.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,255.10	20,255.10
210803	Даатгалын үйлчилгээ	6,198.00	6,198.00
210807	Газрын төлбөр	1,166.60	1,166.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	839.26	839.26
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,390.80	10,390.80
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,390.80	10,390.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	828,867.35	828,867.35
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,320.00	40,320.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	115,500.00	115,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	308,358.03	308,358.03
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	355,989.32	355,989.32

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,700.00	8,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,437,051.30	4,432,769.30
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,405,051.30	4,399,438.78
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,405,051.30	4,399,438.78
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	32,000.00	33,330.52
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,000.00	33,330.52
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.19	0.19
620002	Гүйцэтгэх ажилтан	0.14	0.14

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ мян.төг /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		16,684.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ		16,684.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		16,684.16
2104	Хангамж, бараа материалын зардал		16,684.16
210402	Тээвэр, шатахуун		16,684.16
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		16,684.16
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		16,684.16
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,058.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,625.56
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Б.Жалбаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн МН/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хилийн цэргийн 0277 дугаар анги нь Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах гэсэн ерөнхий зорилгын хүрэнд тус байгууллага "Итгэл дүүрэн сэтгэл хангалуун хилчин" гэсэн зорилтын хүрээнд улсын хил хамгаалалтын үйл ажиллагааг явуулж байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хилийн цэргийн 0277 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 4,964,764.8 мянган төгрөгийн 1 хувь буюу 49,647.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 34,753.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,665.6	3,642.0	1,976.4
Бараа материал	1,217,450.6	1,372,550.9	155,100.3
Үндсэн хөрөнгө	4,322,545.2	4,010,934.3	-311,610.9
Нийт хөрөнгө	5,541,661.4	5,387,127.2	-154,534.2
Өр төлбөр	0	34,785.3	34,785.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,541,661.4	5,352,341.9	-189,319.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,541,661.4	5,387,127.2	-154,534.2

Авлага дансны үлдэгдэл 3,642.0 мянган төгрөг болж өссөн нь 2021 оны 11-р сард санхүүгийн ажилтан солигдож, алба хаагчид болон харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэх хугацаа бага байсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,372,550.9 мянга болж өссөн нь бусад төсөвт байгууллага болон дээд шатны төсөв захирагчаас 884,956.2 мянган төгрөгийн бараа материалын хангалт хийгдсэн, малын нас дэвшилтийг тооцсон зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,010,934.3 мянган төгрөг болж буурсан нь элэгдлийн зардал болон дараах хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

- ✓ Төсвийн хөрөнгөөр 3,200.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер худалдан авсан ,
- ✓ ХХЕГ-аас хөрөнгө оруулалтаар 78,108.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн
- ✓ Хилийн цэргийн 0164 дүгээр ангиас 2,731.0 мянган төгрөгийн дуран нийлүүлэгдсэн

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,352,341.9 мянган төгрөг болж буурсан нь хуримтлагдсан үр дүн 162,525.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 4,437,051.3 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,405,051.3 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 32,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,399,769.3 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 33,330.5 мянган төгрөгийн, нийт 4,432,769.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 4,432,769.3 мянган төгрөгийг зарцуулж, 5,612.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэхүү буцаан төвлөрүүлэлт нь

үндсэн үйл ажиллагааны орлогын давсан хэсэг болон тайлант онд хэмнэгдсэн зардлын зарцуулаагүй үлдэгдэл байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 16,684.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- ХХЕГ-ын хангалт үйлчилгээний албанаас хилийн манаанд гарч буй алба хаагчдыг МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль өгүүлэхэд тээвэрлэх шатахууны зардалд 1,058.6 мянган төгрөг
- Ойн судалгаа хөгжлийн төвөөс хил орчмын байгаль орчны харуул хамгаалалтын үйл ажиллагаанд зориулан 8,500.0 мянган төгрөг
- Тус байгууллагын өөрийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 7,125.6 мянган төгрөг зэрэг байна.

Нэмэлт орлогыг зориулалтын зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс нууцын чанартай 7 төрлийн 84 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах шаардлагагүй, үлдсэн мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл” үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 44,114.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах мал, махыг бэлтгэхдээ нутгийн иргэдээс худалдан авалтыг хийсэн байна. Ингэхдээ 24,014.5 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангалтгүй хийсэн, мөнгө хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулж, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, 17,701.1 мянган төгрөгийн зардал нь харилцагч байгууллагын төлбөрийн баримтгүй зэргээс нийт 41,715.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.1 “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалтууд, болон санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Мал, махыг бэлтгэхдээ анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж, мөнгө олгосон баримтад гарын үсэг зуруулж, тамга тэмдгээр баталгаажуулж, харилцагч байгууллага,

иргэдтэй төлбөр тооцоо хийсэн тухай бүр төлбөрийн баримтыг хэрэглэгчийн системд бүртгүүлж хяналт тавьж байх

2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

2.1. Илрүүлэлт:

Албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан 1,915.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/99 дугаар тушаалаар батлагдсан Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах баталгаажуулах журмын 2 дугаар хэсгийн 2.2.1 “ажил олгогч нь даатгуулагчид олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг үнэн зөв тодорхойлох” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын 2021 оны эхний 6 сарын тайланд залруулга хийх

3. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

Хилийн цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн даатгалын төлбөрийг албан хаагчдын НДШ-д гүйлгэн зарцуулсан 487.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хилийн цэргийн 0277 дугаар анги	3	44.1							3	44.1

БОЛОВСРУУЛСАН:


АУДИТОР



Б.ЖАЛБАА

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЗАЯА

ATA6366 9039376
092110 2022.02.14